



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 02. 20 № 3/275
танай _____-ны № _____-т
Аудитын гэрчилгээ

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.АМАРСАНАА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА
37A0122



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН”
ТӨҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитынтайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор
С.Энхзаяа
Утас:261663
Цахимхаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Н.Золзаяа
Утас: 261885
Цахимхаяг:zolzayan@audit.gov.mn

Ахлах Аудитор:Н.Батсайхан
Утас: 260512
Цахимхаяг:
batsaikhann@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний
аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
ЗГ-н 4-р байр
Цахим хуудас: www.audit.mn

“Б энд С Аудит” ХХК
Захирал Д.Дашхорлоо
Утас:70114810
Цахимхаяг:
audit_bc@yahoo.com

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3:Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.2, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дах заалтын дагуу Үндэсний аудитын газрын захиалгаар “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ/2017/44/СТА-ТӨҮГ/аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийлээ.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарттүүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт оршино.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 26-наас 2017 оны 02 дүгээр сарын 23-ийг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн “Б энд С Аудит” ХХК-ын аудитын 1-р багийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, аудиторын туслах П.Ундрах нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын 07-ны 1/52 дугаар албан бичгийн дагуу “Б энд С Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Б энд С Аудит” ХХК аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 26-наас 2017 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайлан, гэрчилгээг 2017 оны 02 дугаар сарын 21-нд “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь Эрчим хүчний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн аудитын тухай, ААНОАТ-ын тухай, НӨАТ-ын тухай, Нийгмийн даатгалын тухай, ХХОАТ-ын тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн Сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь “Хамтдаа МУ-ын эрчим хүчний салбарын ирээдүйг тодорхойлохын төлөө”, эрчим хүчний салбарт шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны ажил, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, олон улсын эрчим хүчний салбарын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хүрээлэнгүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрчим хүчний салбарт инновацийн төслүүдийг хэрэгжүүлэхээр эрчим хүчний салбарт эрчимтэй үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрдэм шинжилгээ, судалгааны хэлтэс, зураг төслийн хэлтэс, захиргаа, удирдлагын хэлтэс болон бусад мэргэжилтнүүдийг шуурхай удирдлагаар ханган, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамж болон бусад талаар дэмжин ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасны дагуу төсвийн шууд захирагч “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын төсвийг захиран зарцуулж байна.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт, хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 14-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2014 оноос шинэчилж мөн оноос мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “MACS” Инфо системс

програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 9,947.6 мянган төгрөг гэж тооцов. Учир нь: Нийт орлого болон зардлаас материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул нийт зардлын 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

Дотоод хяналт

Аудитор санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хяналаа.

Ийнхүү хянахдаа “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтыг санхүүгийн, хяналтын эрсдэл байвал зохих горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт ямар байгааг тогтоосон. Аудитор байгууллагын удирдлагад бүртгэл санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтад илэрсэн сул талуудыг тухай бүрд нь мэдэгдэж зөвлөмж өгч ажилласан.

Орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь 2016 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөг Төрийн өмчийн хороогоор батлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна. 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн зорилтот түвшингийн төлөвлөгөөнд нийт орлогыг 1,004,350.0 мянган төгрөг, нийт зардлыг 998,080.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 405,754.3 мянга, үндсэн бус үйл ажиллагааны орлого 276,288.5 мянга, нийт 682,042.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 322,308.0 мянга буюу 47.2 хувиар тасалсан байна.

Тайлант хугацаанд борлуулсан бүтээгдэхүүний өртөг 169,240.8 мянга, удирдлагын зардалд 572,880.2 мянга, бусад зардалд 4,081.4 мянга, нийт 746,202.4 мянган төгрөг зарцуулж, 63,742.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь “Эрчим хүчний хөгжлийн төв” нь засгийн газрын 360-р тогтоолыг хэрэгжүүлээгүй 0.18%-ийн орлогыг өөртөө төвлөрүүлсэн, мөн Эрчим Хүчний Яамнаас зарласан зурагын тендерт оролцох боломжгүй болсон зэрэг шалтгаанаар орлого тасарч алдагдалтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 394-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” тухай журам батлагдсаны дагуу “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь байгууллагын вэб сайтад шилэн дансаа нээж 2016 онд 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээ байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 дансанд эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс мөнгөн хөрөнгө, авлага, цалин хөлс, батлагдсан орлогыг төвлөрүүлж чадаагүй зэрэгзөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”, “хамааралтай байх”, “эрх ба үүрэг”, “үнэлгээ”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн”ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийнсанхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, орлого, тээвэр шатахуун, бичиг хэрэг, албан томилолт, цалин хөлс зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 81.6 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад дараах алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,113.0 мянган төгрөгийн гүйлгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал, гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” заалтыг мөрдөж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн:Аудитийн хугацаанд баримтын бүрдлийг хангуулан зөрчлийг арилгуулав.

2. Тээвэр шатахууны зардал 974.9 мянган төгрөгийг бусад зардалд бүртгэсэн, мөнгөн гүйлгээний тайланд хүүгийн орлого 253.9 мянган төгрөгийг бусад орлогоор бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хамааралтай байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна. Энэ нь Сангийн Сайдын 77 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:Аудитийнхугацаанд санхүүгийн тайланд залруулга хийж зөрчлийг арилгасан.

3. Санхүүгийн тайланд тусгагдсан 7,641.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байгаань санхүүгийн тайлангийн

толилуулга, үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. Ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо унаа хоолны мөнгө 1,607.3 мянган төгрөгийг дундаж цалинд оруулж тооцсон нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хамааралтай байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Энэ нь НХХСайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох" журмын 4 "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийн талаар удирдлагад АЛБАН ШААРДЛАГА хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Тайлант хугацаанд залруулагдаагүй алдаа байхгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудит хийх явцад анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал үгүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,590.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,607.3 мянган төгрөгт албан шаардлага өгч, 3,341.8 мянган төгрөгийг аудитын явцад залруулж, 7,641.3 мянган төгрөгийг зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Монголиан рейтинг бизнес аудит” ХХК аудит хийж 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг 100% хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН” ТӨҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Авлагын талаархуудас 3

Менежментийн захидал

“Б энд С Аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг “Б энд С Аудит” ХХК-ийн аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

“Б энд С Аудит” ХХК энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

“Б энд С аудит” ХХК-н ажиглалт

Санхүүгийн тайланд тусгагдсан 7.641.3мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн толилуулга, үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

“Б энд С аудит” ХХК-н зөвлөмж

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага санхүүгийн ажилтнуудад танилцуулж баталгаажуулсан болно.

Байгууллагын нэр: "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,302,217.90	20,113,464.13
Дансны авлага	308,468,135.00	294,890,363.00
Татвар, НДШ-ийн авлага	377,222.69	
Бусад авлага	1,540,926.00	1,446,819.00
Бараа материал	24,724,832.55	25,747,412.97
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
Эргэлтийн хөрөнгийн дүн	338,413,334.14	342,198,059.10
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	80,848,669.70	48,286,544.33
Биет бус хөрөнгө	219,238,574.55	219,238,574.55
Дуусаагүй барилга		
Хуримтлагдсан элэгдэл		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	300,087,244.25	267,525,118.88
Нийт хөрөнгө	638,500,578.39	609,723,177.98
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны өглөг	38,375,000.07	29,239,444.07
Цалингийн өглөг		
Татварын өр	4,324,304.32	41,037,130.39
НДШ-ийн өглөг		8,112,362.24
НӨАТ-ын өглөг		
ЭМНД-ын шимтгэлийн өглөг		
Урьдчилж орсон орлого		247,544.63
Богино хугацаат өр төлбөрийн дүн	42,699,304.39	78,636,481.33
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өглөг		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн дүн	42,699,304.39	78,636,481.33
<i>Эзэмшигчдийн өмч</i>		
Төрийн	50,942,564.92	50,942,564.92
Хувийн	50,942,564.92	50,942,564.92
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	241,520,901.21	241,520,901.21
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	4,170,141.37	4,170,141.37
Хуримтлагдсан ашиг	299,167,666.50	234,453,089.15
Тайлангийн үеийн ашиг		- 64,714,577.35
Өмнөх үеийн ашиг		299,167,666.50
Эзэмшигчдийн өмчийн дүн	595,801,274.00	531,086,696.65
Нийт өр төлбөр ба эзэмшигчийн өмч	638,500,578.39	609,723,177.98

Байгууллагын нэр: "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
Борлуулалтын орлого /цэвэр орлого/	551,802,267.66	405,754,344.69
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	79,644,827.10	169,240,787.11
Нийт ашиг	472,157,440.56	236,513,557.58
Түрээсийн орлого	1,283,636.00	
Хүүний орлого	3,355,304.10	353,443.84
Бусад орлого	347,305,562.24	276,288,493.60
Ерөнхий ба удирдлагын зардал	- 806,348,684.12	- 572,880,190.61
Борлуулалт маркетингийн зардал		
НДШ-ийн зардал		
Бусад зардал		
Санхүүгийн зардал		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	646,385.67	98,520.47
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/		
Хүү торгууль хөнгөлөлтийн ашиг /алдагдал/		
Гадаад валютын ханшийн зөрүүний ашиг/алдагдал/	(11,766,152.76)	(4,081,417.86)
Бусад ашиг алдагдал		
Олз гарзын дүн		
Бусад		
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/-ын дүн		
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	6,633,491.69	- 63,707,592.98
Орлогын татварын зардал	1,775,325.88	35,344.38
Татварын дараах ашиг /алдагдал/	4,858,165.81	- 63,742,937.36
Онцгой шинжтэй зүйлс-цэвэр		
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	4,858,165.81	- 63,742,937.36

Байгууллагын нэр: "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ

Бэлтгэсэн огноо: 2017.01.30

Тайлант хугацаа: 2016.12.31

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Аудит хийгдээгүй

	Нэмж төлөгдсөн	Эзний өмчийн	Хөрөнгийн дахин	Хуримтлагдсан	Нийт дүн /төгрөг/
2016 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	50,942,564.92	4,170,141.37	241,520,901.21	299,167,666.50	595,801,274.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
Залруулсан үлдэгдэл	50,942,564.92	4,170,141.37	241,520,901.21	299,167,666.50	595,801,274.00
Зарласан ногдол ашиг				- 971,640.00	- 971,640.00
Тайлант үеийн ашиг				- 64,714,577.35	- 64,714,577.35
2016 оны 12 сарын 31 ний үлдэгдэл	50,942,564.92	4,170,141.37	241,520,901.21	233,481,449.15	530,115,056.66

Аудит хийгдсэн

	Нэмж төлөгдсөн капитал	Эзний өмчийн бусад хэсэг	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн /төгрөг/
2016 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	50,942,564.92	4,170,141.37	241,520,901.21	299,167,666.50	595,801,274.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	50,942,564.92	4,170,141.37	241,520,901.21	299,167,666.50	595,801,274.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	- 971,640.00	- 971,640.00
Тайлант үеийн ашиг	-	-	-	- 64,714,577.35	- 64,714,577.35
2016 оны 12 сарын 31 ний үлдэгдэл	50,942,564.92	4,170,141.37	241,520,901.21	233,481,449.15	530,115,056.66

Байгууллагын нэр: "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ
 Бэлтгэсэн огноо: 2017.01.30
 Тайлант хугацаа: 2016.12.31

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	478,983,012.32	685,633,962.51
Татаас санхүүжилтийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,887,864.00	7,272,105.00
Бусад орлого	151,755,229.59	46,059,357.50
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	639,626,105.91	738,965,425.01
Үйл ажиллагааны зарлага		
Ажилчдад олгосон мөнгө	403,405,406.00	293,976,990.50
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	101,800,260.00	71,061,079.00
Бараа материал худалдан авахад төлсөн	205,105,176.03	60,852,608.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	2,343,130.00	5,690,199.55
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	23,007,969.94	8,756,911.00
Татварын байгууллагад төлсөн	60,528,572.00	19,947,310.00
Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө		
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө		
Түрээсийн зардал		
Төлсөн хүү		
Төлсөн орлогын болон бусад татвар		
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	9,705,613.00	7,899,386.00
Бусад мөнгөн зарлага	204,217,236.99	253,351,498.57
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,010,113,363.96	721,535,982.62
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(370,487,258.05)	17,429,442.39
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	353,443.84
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүгийн орлого		353,443.84
Бусад		
Мөнгөн зарлагын дүн	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Бусад		
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ дүн	-	353,443.84
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(25,660,000.00)	(971,640.00)
Мөнгөн орлогын дүн		
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Бусад		
Мөнгөн зарлагын дүн	25,660,000.00	971,640.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө		
Төлсөн ногдол ашиг	25,660,000.00	971,640.00
Бусад		
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(396,147,258.05)	16,811,246.23
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	399,449,475.95	3,302,217.90
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,302,217.90	20,113,464.13